

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

<b>БЦГ</b>	Байгалийн Цогцолборт Газар
<b>БОАЖЯ</b>	Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам
<b>БОНХАЖЯ</b>	Байгаль Орчин Ногоон Хөгжил Аялал Жуулчлалын Яам
<b>БНБД</b>	Барилгын Норм Ба Дүрэм
<b>БОМТ</b>	Байгаль Орчны Менежмент Төлөвлөгөө
<b>БОННУ</b>	Байгаль Орчны Нөлөөллийн Нарийвчилсан Үнэлгээ
<b>БОНМС</b>	Байгаль Орчин, Нийгмийн Менежментийн Систем
<b>БО</b>	Байгаль Орчин
<b>БОНЭЗ</b>	Байгаль Орчин, Нийгэм Эдийн Засаг
<b>Д.Т.Д</b>	Далайн Түвшнээс Дээш
<b>ЕБС</b>	Ерөнхий Боловсролын Сургууль
<b>ЗГ</b>	Засгийн Газар
<b>МУ</b>	Монгол Улс
<b>МУУН</b>	Монгол Улсын Улаан Ном
<b>НЭЗ</b>	Нийгэм Эдийн Засаг
<b>ОНТХГН</b>	Орон Нутгийн Тусгай Хамгаалалттай Газар Нутаг
<b>СӨБ</b>	Сургуулийн Өмнөх Боловсрол
<b>ТХГН</b>	Тусгай Хамгаалалттай Газар Нутаг
<b>УТХГН</b>	Улсын Тусгай Хамгаалалттай Газар Нутаг
<b>ХХК</b>	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

## ТЭМДЭГЛЭГЭЭ

<b>Га</b>	Гектар
<b>Гц</b>	Герц
<b>дБ</b>	Децибел
<b>Км</b>	Километр
<b>м</b>	Метр
<b>м<sup>2</sup></b>	Метр квадрат
<b>м<sup>3</sup></b>	Метр куб
<b>Па</b>	Паскаль
<b>Тн</b>	Тонн

## АГУУЛГА

<b>БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ</b> .....	<b>4</b>
1.1. ТӨСЛИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ .....	4
1.2. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ .....	7
1.2.1. ТӨСЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	9
1.3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН БАЙДАЛ .....	9
<b>1.4. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ</b> .....	<b>9</b>
<b>БҮЛЭГ.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ</b> .....	<b>11</b>
<b>ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ</b> .....	<b>13</b>
3.1. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ .....	13
3.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ .....	13
<b>БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАНИЛЦУУЛГА</b> ...	<b>17</b>
<b>4.1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	<b>19</b>
4.1.1. Байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	20
4.1.2. Нөхөн сэргээлт, ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө .....	24
4.1.3. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө .....	26
4.1.4. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө .....	26
4.1.5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	27
4.1.6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	28
4.1.7. Удирдлага, зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ .....	32
<b>4.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР</b> .....	<b>34</b>
4.3. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	35

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

<i>Хүснэгт 1. Нөлөөллийг тооцох аргачлал</i> .....	<i>13</i>
<i>Хүснэгт 2. Байгаль орчинд нөлөөлөх байдлыг тодорхойлох шалгуур</i> .....	<i>14</i>
<i>Хүснэгт 3. Агаарын чанарт нөлөөлөх байдлын үнэлгээний матриц</i> .....	<i>15</i>
<i>Хүснэгт 4. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвчид нөлөөлөх байдлын үнэлгээний матриц</i> .....	<i>15</i>
<i>Хүснэгт 5. Гадаргын болон газрын доорх усанд нөлөөлөх байдлын үнэлгээний матриц</i> .....	<i>16</i>
<i>Хүснэгт 6. Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээний матриц</i> .....	<i>16</i>
<i>Хүснэгт 7. Амьтны аймагт нөлөөлөх байдлын үнэлгээний матриц</i> .....	<i>16</i>
<i>Хүснэгт 8. БОМТөлөвлөгөөний зардлын задаргаа /мян.төг/</i> .....	<i>19</i>
<i>Хүснэгт 9. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний нийт зардал /мян.төг/ .....</i>	<i>19</i>
<i>Хүснэгт 10. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал /мян.төг/.....</i>	<i>20</i>
<i>Хүснэгт 11. Нөхөн сэргээлт, ногоон байгууламж байгуулах төлөвлөгөөний зардал /мян.төг/.....</i>	<i>25</i>
<i>Хүснэгт 12. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал /мян.төг/ .....</i>	<i>27</i>
<i>Хүснэгт 13. Ангилан ялгах хог хаягдлууд</i> .....	<i>29</i>
<i>Хүснэгт 14. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал /мян.төг/.</i>	<i>31</i>
<i>Хүснэгт 15. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний зардал /мян.төг/ .....</i>	<i>33</i>
<i>Хүснэгт 16. Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр /мян.төг/.....</i>	<i>34</i>

Хүснэгт 17. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө ..... 35

## **ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1. Төслийн байршлын тойм зураг .....	6
Зураг 2. Төслийн батлагдсан төлөвлөлт .....	7
Зураг 3. Төслийн харагдах байдал .....	8
Зураг 4. Хог хаягдлын цэгийн шийдэл .....	28

# БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ

## 1.1. ТӨСЛИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

**Төслийн нэр:** Аялал жуулчлалын цогцолбор байгуулах төсөл

**Төслийн зорилго:** Төслийн зорилго нь аялагчдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, гэр бүлтэйгээ амрах, зугаалах орчин нөхцөлийг бүрдүүлэх, байгальд ээлтэй, дэвшилтэд технологийг ашигласан аялал жуулчлалын цогцолбор байгуулах юм.

**Зорилт:**

- Төслийн хүрээнд санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх
- Ажиллах боловсон хүчнийг сургах бэлдэх
- Тоног төхөөрөмжийг татан авалт хийж, бэлтгэл ажил хангах
- Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах
- Үйлчилгээгээ зах зээлд таниулах сурталчлах
- Үйл ажиллагаа өргөжүүлж, үр ашгийг нэмэгдүүлэх
- Шаардлагатай худалдан авалтыг хийх

**Төслийн үндэслэл:** Монгол Улсын аялал жуулчлалын салбар нь эдийн засгийн өсөлтөд эзлэх хувь хэмжээний хувьд бага ч хурдацтай хөгжиж буй салбар юм. 2019 он нь Монгол Улсын аялал жуулчлалын салбарт өсөлт авчирсан жил байв. Нийт жуулчдын тоо 570,262 буюу дээд хэмжээнд хүрч, 607 сая ам.доллар буюу 1.7 их наяд төгрөгийн цэвэр ашиг олсон статистик байна.

Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-д “үндэсний нэгдмэл үнэт зүйл” буюу үндэсний бахархлыг бэхжүүлэх асуудлыг зорилгын тэргүүлэх асуудалд тавьсан. Аялал жуулчлал нь Монголын ард иргэдийн өөрийн эх орноор бахархах сэтгэлийг бэхжүүлэх бол харин гадаадын жуулчид Монголын гайхамшигт байгаль, нүүдэлчин соёлыг мэдэрснээр Монголын сэтгэл татам байдлыг дахин үнэлэх гэсэн ач холбогдолтой. Орос, Хятад гэсэн том гүрнүүдийн дунд хавчуулагдсан ердөө 3.4 сая хүн амтай Монгол улс дэлхий дахинд аялал жуулчлалаар дамжуулан үүд хаалгаа нээснээр, улсынхаа хил хязгаарыг дэлхийн өнцөг булан бүрд хүргэн өргөжүүлэх боломжтой бөгөөд энэ нь “Алсын хараа 2050” - ийн зорилгыг биелүүлэхэд ч чухал ач холбогдолтой юм.

Тус төслийн байршил байгалийн өвөрмөц тогтоц бүхий “Дөргөн нуур”-ын ойролцоо байрлах тул Говь-Алтай аймаг, Ховд аймгаас зорчиход илүү хялбар, цаашид тухайн аймгуудын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд багахан ч гэсэн хувь нэмэр оруулж, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх давуу талыг бий болгоно.

**Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага**

*Хүснэгт 1.1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл*

Аж ахуйн нэгжийн нэр:	“Дэгрээ дөргөн” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9011846395
Регистрийн дугаар:	6960316
Хаяг:	Улаанбаатар хот, Хан-Уул, 3-р хороо, үйлдвэр 17,16 тоот
Утас:	859102389,99110189


**Төслийн байршил:** Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах Дөргөн нуур нэртэй газарт 10 га талбайд хэрэгжинэ. Тус төслийн талбай нь Улсын болон орон нутгийн ТХГН-т байрлаагүй.

*Хүснэгт 1.2. Төсөл хэрэгжих газрын байршил*

№	Уртраг	Өргөрөг	Урт
1.	544768.35	5274394.47	167.22
2.	544668.16	5274260.69	755.35
3.	544197.81	5273670.04	695.72

4.	543761.47	5273128.51	77.33
5.	543818.76	5273076.55	731.80
6.	544265.57	5273655.70	892.86
7.	544810.42	5274362.55	36.63
8.	544781.28	5274384.76	16.17

## ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙРШЛЫН ЗУРАГ




Зураг 1. Төслийн байршлын тойм зураг

## 1.2. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ

Төслийн бүтээн байгуулалт нь нийт 4 үе шатнаас бүрдэх ба 2023-2028 онд барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэн бүрэн ашиглалтад оруулахаар төлөвлөсөн.

Төслийн талбайн зохион байгуулалтыг нийт 5 хэсэгт хувааж төлөвлөлтөд тусгасан ба үүнд:

1. Туслах хэсэг – Ажилчдын байр болон хангамжийн агуулахын хэсэг.
2. Гэр бүлийн амрах хэсэг: Энэ хэсэгт 8 ширхэг хаус байгуулагдах ба нэг хаусд байрлах хүний тоо 6 хүртэл хүн байрлуулахаар төлөвлөж байна.
3. Уламжлалт амрах хэсэг: Энэ хэсэгт 20 ширхэг монгол гэр байрлах ба нэг гэрт 4 хүртэлх хүн байрлуулахаар төлөвлөж байна.
4. Олон улсын амрах хэсэг: Энэ хэсэгт олон улсын стандартын дагуу 4 давхар зочид буудал байрлах ба нийт хүн хүлээн авах хүчин чадал нь 70 орчим хүн авч байрлуулахаар төлөвлөж байна.
5. Тусгай амрах хэсэг: Энэ хэсэгт зорилтот хүмүүст үйлчлэхээр тансаг зэрэглэлийн 4 улирлын 9 хаус байгуулагдах ба нэг хаусд 6 хүртэлх хүн хүлээн авч байрлуулахаар төлөвлөж байна.



**Зураг 2. Төслийн батлагдсан төлөвлөлт**

Ийнхүү төсөл бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхэлсэн тохиолдолд нэг ээлжид 250 амрагч хүлээн авах ба 20 ажилтан ажиллана.

Төслийн үед амрагчдад зориулсан аялал жуулчлалын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. Үүнд:



Зураг 3. Төслийн харагдах байдал



## 1.2.1. ТӨСЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ажлын төлөвлөгөөг гурван үе шатаар тодорхойлов. Үүнд:

Нэгдүгээр үе шат: Талбайн бэлтгэл ажлууд

- Барилгын зураг төсөл гаргах, холбогдох техникийн даалгавар, зөвшөөрөл, бичиг баримтуудыг мэргэжлийн байгууллагатай хамтран бүрдүүлэх
- Түүхий эд материалыг төслийн сонголтын дагуу бэлтгэх
- Туршлага дадлага бүхий ажилчидтай удаан хугацааны гэрээ байгуулан ажиллах
- Барилга угсралтын ажлын өмнөх хөрс боловсруулалт хийж бэлтгэх
- Цахилгааны болон усны шугам тавих, сантехникийн ажлыг хийж гүйцэтгэх
- Бохир зайлуулах цооногийг бэлтгэж, тоноглох ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх

Хоёрдугаар үе шат: Барилга угсралтын ажлууд

- Хөрс бэлдэх, суурь цутгах, барилга угсралтын ажил, дотно гадна заслын ажлууд

Гуравдугаар үе шат: Гадна орчны тохижилт

- Автомашины зам, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж, нарлах талбай зэрэг гадна орчны тохижилтын ажлууд хийгдэнэ. Зураг төслөөр тухайн барилга, байгууламжийн загвар дизайн, хийц, материал, ажлын хэмжээ тодорхойлогдоно.

## 1.3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН БАЙДАЛ

**Дэд бүтцийн хөгжил:** Аялал жуулчлалын цогцолбор төсөл нь Говь-Алтай аймгийн хөх морьт сумын нутаг дэвсгэрт хэрэгжих баруун таван аймгийг хамарсан 10 га талбайг хамран байрших бөгөөд төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай дэд бүтцийн асуудлыг дараах байдлаар шийдсэн.

Төслийн талбай нь Улаанбаатар хотоос 1000-3000 гаруй км зайд оршдог. Төлөвлөж байгаа газар нь Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэрт хамрагдах бөгөөд Ховд, Завхан аймгийн нутагтай залгаа оршино. Цэнгэг агаар, зүлэг ногоо, мод бут, амарч алжаал тайлах ногоон байгууламж зэргээр хүрээлэгдсэн газар сэтгэл амар амьдрах боломжийг бүрдүүлж өгнө. Айл өрхийн амгалан тайван, аюулгүй байдлыг хангах үүднээс нэгдсэн камержуулалт, харуул хамгаалалттай байлгана.

Гэр бүлийн хамт чөлөөт цагаараа спортоор хичээллэж эрүүл, идэвхтэй амьдрах нөхцөлийг бүрэн хангахуйц хүүхдийн тоглоомын талбай, аэробек фитнес төв, алжаал тайлах ногоон байгууламж, нарлах талбай зэрэг бүхнийг төвлөрүүлсэн төгс байгууламж байна.

**Цахилгаан хангамж ба халаалт:** Цахилгаан эрчим хүчний хэрэгцээг төвлөрсөн эх үүсвэрээс хангахаар төлөвлөсөн.

**Зам харилцаа:** Төсөл хэрэгжих газар нь харилцаа холбооны бүх үүрэн операторуудын сүлжээ сайн барихаас гадна авто замын орчин сайтай.

## 1.4. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Хог хаягдлын менежмент гэдэг нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хог хаягдлаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор хог хаягдлын эх үүсвэрийг бууруулах, ангилан ялгах, цуглуулах,

тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах бүхий л процессыг хянаж сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ юм.

Төсөл хэрэгжүүлэгч нь хог хаягдлын менежментийн хүрээнд цаашдын авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, хог хаягдлыг газар дээр нь ангилан ялгах нөхцөл бололцоог хангаж ажиллах үүрэгтэй.

### **Хатуу хог хаягдал:**

#### **2. Төслийн үйл ажиллагааны явцад гарах хатуу хог хаягдал**

Хэрэв төсөл нь бүрэн хүчин чадлаараа ажиллана /100 хүн/ гэж үзвэл хоногт 50 кг, сард 1500 кг, жилд 18 тн хатуу хог хаягдал гарах тооцоотой байна. /Тооцоог Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 12 сарын 25-ны өдрийн А/368 дугаар тушаалын хавсралт Энгийн хог хаягдлын норматив хэмжээг тогтоох аргачлалын дагуу 1 хүнээс хоногт 0.5 кг хог хаягдал гарахаар хийв/.

Хатуу хог хаягдлыг хэмжээнээс нь хамааруулж сард 2 буюу түүнээс дээш удаа Говь-Алтай аймгийн Хөх морьт сумын хогийн цэг рүү зөөвөрлөж хаяна. /Хөх морьт сумын Засаг Даргын Тамгын Газартай хог хаягдлыг устгах гэрээ байгуулах шаардлагатай/

### **Шингэн хаягдал**

Унд ахуйн хэрэглээнээс үүсэж зайлуулагдах бохир усны хэмжээг “Внутренний водопровод и канализация зданий” СНиП 2.04.01-85-ын дагуу тооцвол:

✚ Барилгын үе шатны унд ахуйн усны хэрэглээнээс гарсан бохир ус:

Ажилчдын ахуйн хэрэглээнээс үүсэх бохир усны хоногийн зайлуулалт:

$$Q_{\text{хон}} = q_v \cdot N = 3.0 \text{ м}^3 / \text{хоног} \times 0.7 = 0.21 \text{ м}^3 / \text{хон}$$

Ахуйн хэрэглээнээс төслийн нэг жилийн хугацаанд үүсэх бохир ус:

$$Q_{\text{нэг жил}} = Q_{\text{хон}} \cdot T = 0.21 \text{ м}^3 / \text{хон} \cdot 360 \text{ хон} = 756.0 \text{ м}^3$$

✚ Төсөл хэрэгжих үеийн унд ахуйн усны хэрэглээнээс гарсан бохир ус:

Ахуйн хэрэглээнээс үүсэх бохир усны хоногийн зайлуулалт:

$$Q_{\text{хон}} = q_v \cdot N = 49.35 \text{ м}^3 / \text{хоног} \times 0.7 = 34.5 \text{ м}^3 / \text{хон}$$

Ахуйн хэрэглээнээс төслийн нэг жилийн хугацаанд үүсэх бохир ус:

$$Q_{\text{нэг жил}} = Q_{\text{хон}} \cdot T = 34.5 \text{ м}^3 / \text{хон} \cdot 360 \text{ хон} = 12436.2 \text{ м}^3$$

## БҮЛЭГ.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### Физик газарзүй

Говь-Алтай аймаг нь 1940 онд байгуулагдсан 141.2 мянган ам.км нутаг дэвсгэртэй, засаг захиргааны нэгжийн хувьд 18 сум 2 тосгон 83 багтай, 2005 оны байдлаар 63.5 мянган хүн амтай, баруун болон хойд талаараа Ховд, Увс, Завхан аймаг зүүн талаараа Баянхонгор аймагтай, өмнөд, баруун урд талаараа БНХАУ-тай хил залган оршдог, манай улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулдаг томоохон аймгийн нэг юм. Аймгийн төв Алтай хот нь Хантайшир уулын өвөр бэлд Улаанбаатар хотоос 1001 км зайтай оршдог. 2005 оны тоо бүртгэлээр 20,1 мянган хүн амтай байв.

### Уур амьсгалын нөхцөл

Говь-Алтай аймаг өндөр уул, ой, тал говь цөл хосолсон өвөрмөц нөхцөлтэй, байгалийн хэд хэдэн бүс бүслүүр багтаасан өргөн уудам нутагтай юм.

Уур амьсгалын мужлалын хувьд Алтай, түүний салбар уулс орчмын нутаг нь чийглэгдүү хүйтэн таг, хуурай хүйтэн өндөр уул нь хуурай сэрүүн уулын хээрийн мужид хамрагддаг. Нарны цацраг, гадаргын халалт, хүйтэн агаарын урсгал нэмэгдэх зэргээс зуны улиралд 100 м өгсөх тутам агаарын температур 0.6-0.70 -аар буурдаг байна. Энэ үзэгдэл зөвхөн дулааны улиралд ажиглагддаг бөгөөд хүйтний улиралд ууландаа орчин тойрныхоо хөндий хотгороос арай дулаан болдог. Харин хотгор газар агаарын хөдөлгөөн бага, орж ирсэн агаар нь удаан хадгалагддагаас өвөл хүйтэн, зун халуун байх нь ердийн үзэгдэл юм.

### Ус

Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэр ус зүйн сүлжээний хувьд Төв Азийн гадагш урсацгүй ай савд багтдаг. Гадаргын усны хуваарилалтаар Монгол-Алтайн ар болон өвөр хажуугийн мужид хамрагдана. Тус аймаг гадаргын усны сүлжээний нягтрал бага, жигд бус тархсан цэнгэг усны нөөцөөр харьцангуй хязгаарлагдмал уур амьсгалын нэн эмзэг өргөмтгий бүс нутаг юм. Аймгийн усны нөөцийг гол горхи, нуур цөөрөм, мөнх цас, газрын доорхи ус, хиймэл нуур гэж ангилж болох юм. Эдгээрээс газрын гүний усны нөөц нилээд элбэгтэйд тооцогддог. Хангайн нурууны ноён оргил Отгонтэнгэрийн баруун зүүн сугаас эх авсан Завхан гол нийт 808 км урт бөгөөд ус цуглуулах талбай нь 71210 ам км<sup>2</sup> юм. Тус аймгийн хойд хэсэг Дэлгэр, Тайшир, Жаргалан сумдын нутгаар 300 гаруй км урт замыг туулан урсаж Айраг нуурт цутгадаг. Завхан гол эхэндээ уулархаг, дунд хэсэгтээ говийн уулс толгодоор, адагтаа уулын хормойн элсэн манхнаар урсдаг.

### Ургамал

Зүүнгарын мужийн Өмнөд Монгол Алтайн тойрогт, Алтайн нуруу, түүний салбар уулс ТуваМонголын мужийн Говь-Алтайн тойрогт, Их Нууруудын хотгорын хэсэг нь Тува Монголын мужийн Өмнөд Хангайн тойрогт, Аж Богдоос урагш орших цөл газар Зүүнгарын мужийн Номингийн тойрогт, Эдрэнгийн нуруу, Суман хайрхан, Алтайн өвөр говийн хэсэг бүхэлдээ Алтайн өвөр говь-Бейшаны мужийн Алтайн өвөр говийн тойрогт тус тус багтдаг байна.

Эндээс харвал тус аймгийн нутаг нь ургамлын аймгийн хувьд өвөрмөц онцлогтой, гарал үүслийн хувьд ялгаатай мужуудын заагт байрлах ажээ. Нөгөө талаар нутгийн дунд хэсгээр байрлах Алтайн уулт тогтолцоо нь умардын зүйлүүд өмнө зүг гүн түрж орох нөхцлийг бүрдүүлж байхад уулс дотоодын хотгорууд нь цөлийн элементүүд умар зүг алс нэвтрэн түрж ургахад нөлөөлж байдаг. Иймээс шинэсэн ойн тархалтын өмнөд цэгээс хойш заган ойн хэвшил тааралдах нь бий.

---

**Амьтан**

Говь Алтай аймаг нь байгалийн төрөл бүрийн бүс бүслүүрт хамрагдах өргөн уудам нутагтай. Тэнд өндөр уул хад асга, ой, хээр тал, говь цөл, нуур ус, зэгс, шугуй, элсний орчны амьтад хөршлөн амьдардаг. Тус аймагт нийт 5 ангийн 335 зүйл буюу манай орны сээр нуруутан амьдын зүйлийн бүрэлдэхүүний 51.4 хувь нь оршин амьдардагийн зэрэгцээ нэн эртний ховор болон говь цөлийн унаган төрөл зүйлийн амьтад цөөнгүй бий. Алтайн өвөр говьд 7 баг, 16 овгийн 64 зүйл дэлэнтэн амьтан тэмдэглэгдсэн нь манай орны дэлэнтний зүйлийн бүрэлдэхүүний 46 % болж байна. Үүнээс далавчтан 7, туулайтан 3, мэрэгчтэн 33, махчтан 16, туурайтан 6 зүйл тархсан байна.

---

**Тусгай  
хамгаалалттай  
газар**

Тус аймгийн төв хэсгийн уулархаг нутгаар хярс, үнэг, бор туулай зэргээс гадна тарвага, цайвар үлий, алаг даага, зурам болон бусад олон зүйлийн мэргэчид өргөн тархжээ. Алтайн ар говийн цөлөрхөг нутгаар шилүүс, мануул мий эрээн өмхий хүрэн, үен, дэлдэн зараа, үхэр огодой, уссаг багваахай, шар чичүүл, орог зусаг, бозлог зурам, боролзон туулай, хөх шишүүхэй, жирх, солонго, хадны барагчин, цагаан үен зэрэг амьтад өргөн тархсны зэрэгцээ байгалийн аясаар ховордож буй тавируу атигдаахай ч байдаг. Алтайн өвөр говьд 7 баг, 16 овгийн 64 зүйл дэлэнтэн амьтан тэмдэглэгдсэн нь манай орны дэлэнтний зүйлийн бүрэлдэхүүний 46 % болж байна. Үүнээс далавчтан 7, туулайтан 3, мэрэгчтэн 33, махчтан 16, туурайтан 6 зүйл тархсан байна.

---

**Нийгэм эдийн  
засаг**

Говь-Алтай аймаг нь 1940 онд байгуулагдсан 141.2 мянган ам.км нутаг дэвсгэртэй, засаг захиргааны нэгжийн хувьд 18 сум 2 тосгон 83 багтай, 2005 оны байдлаар 63.5 мянган хүн амтай, баруун болон хойд талаараа Ховд, Увс, Завхан аймаг зүүн талаараа Баянхонгор аймагтай, өмнөд, баруун урд талаараа БНХАУ-тай хил залган оршдог, манай улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулдаг томоохон аймгийн нэг юм. Аймгийн төв Алтай хот нь Хантайшир уулын өвөр бэлд Улаанбаатар хотоос 1001 км зайтай оршдог. 2005 оны тоо бүртгэлээр 20,1 мянган хүн амтай байв. Тус аймаг нутаг дэвсгэрийн хэмжээгээр Өмнөговь аймгийн дараагаар улсын хэмжээнд хоёрдугаарт, малын тоогоор Өвөрхангай, Хөвсгөл, Завхан, Увс, Ховд зэрэг аймгуудын дараа 10 дугаарт, нэг хүнд ноогдох малын тоогоор Дундговь, Сүхбаатар аймгийн дараа 3 дугаар өрнөд бүсийн хэмжээнд тэргүүн байранд явж байна.

---

## ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### 3.1. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Энэ бүлэгт төслөөс байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг нөлөөлөлд өртөх орчноор буюу газрын гадарга, уур амьсгал, агаарын чанар, гадаргын болон гүний ус, хөрсөн бүрхэвч, ургамлын аймаг, амьтны аймаг, түүх соёлын дурсгал, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэнд зэрэг чиглэлүүдээр авч үзэн тодорхойлж, тэдгээр нөлөөллийн эрчим, цар хүрээг үнэлэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тусгасан болно.

### 3.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг Байгаль Орчин Ногоон Хөгжлийн Сайдын 2014 оны 04 сарын 10-ны өдрийн А/117 дугаар тушаалын 2 дүгээр хавсралт, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх шинэчилсэн аргачлал болон түүнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2017 оны 12 сарын 31-ны өдрийн А/331 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу хийж гүйцэтгэлээ.

Төслийн үйл ажиллагаанаас үүдэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах ажлыг зохион байгуулахын тулд нөлөөллийн хэмжээг тодорхойлно. Нөлөөллийн хэмжээг тодорхойлох нь тухайн хүний ойлголтоос ихээхэн хамаардаг тул ихэнх тохиолдолд байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрээр дараах шаардлагыг мөрдөх шаардлагатай. Нөлөөллийн хэмжээг 3 хүчин зүйлээр тодорхойлно. Нөлөөлөл тус бүрд дээр дурдсан хүчин зүйл бүр 1, 2, 3 гэсэн үнэлгээ өгөх бөгөөд энэ нь тухайн нөлөөллийн хэмжээ, тархалт, давтамжийг харуулна. Үүнд: Нөлөөллийн хэмжээ, хугацаа, нөлөөлөлд өртөх газар нутаг, нөлөөлөл тохиолдох, давтагдах магадлал.

#### Хүснэгт 1. Нөлөөллийг тооцох аргачлал

Хэмжээ тархалт (M) 1, 2 ба 3	Нөлөөллийн хэмжээг тодорхойлно. (бага, дунд, их) Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хугацааг тодорхойлно. (богино, дунд, урт хугацаа)
Хамрах хүрээ (S) 1, 2 ба 3	Төслийн үйл ажиллагаанаас нөлөөлөлд өртөх газар зүйн байрлал, талбай (тухайн талбай орчимд, арай өргөвтөр талбайд, нэлээд өргөн газар нутгийг хамарсан)
Давтамж/магадлал (F) 1, 2 ба 3	Дахин давтагдах магадлал ба дахин давтагдах тоо (бага магадлалтай, өндөр магадлалтай, тохиолдол нь тодорхой)

Болзошгүй нөлөөллийг хэмжээ, хамрах хүрээ, давтамж гурвын үржвэрээр тооцно.

$$M \times S \times F = \text{Болзошгүй нөлөөллийн хэмжээ}$$

Нөлөөллийн хамгийн бага хэмжээ 1 (1x1x1), хамгийн их хэмжээ нь 27 (3x3x3) байна. Нөлөөллийн хэмжээ 6-аас доош байгаа тохиолдолд үл мэдэгдэх нөлөөлөл гэж үзнэ. Дараах хүснэгтэд хэмжээ, хамрах хүрээ, давтамж гуравт үнэлгээг харгалзуулах журам, нэгдсэн үнэлгээг тооцоолох тухай журмыг харуулсан болно. Хэрвээ тухайн нөлөөлөл хуулийн зохицуулалт хийх шаардлагатай болохоор бол мэдэгдэхүйц нөлөөлөлд тооцогдоно.

**Хүснэгт 2. Байгаль орчинд нөлөөлөх байдлыг тодорхойлох шалгуур**

Төрөл/үнэлгээ Шалгуур	Төрөл/үнэлгээ Шалгуур		
<b>М: Хэмжээ, тархалт</b>			
<b>Түвшин -1</b>	Түвшин -1 Бага болон богино хугацааны нөлөөлөл - энэ хоёр нөхцөлийг зэрэг хангасан тохиолдолд		
<b>Түвшин -2</b>	Дунд зэрэг, эсвэл дунд хугацааны нөлөөлөл - Энэ хоёр нөхцөлийн аль нэгийг хангасан тохиолдолд		
<b>Түвшин -3</b>	Томоохон, эсвэл урт хугацааны нөлөөлөл- Энэ хоёр нөхцөлийг аль нэгийг хангасан тохиолдолд		
<b>Нөлөөллийн түвшин</b>			
Бага зэргийн нөлөөлөл	Хэмжээ, тархалтын хувьд бага	Богино хугацааны	Төсөл дууссанаас хойш 6 сарын хугацаа нөхөн сэргээгдэх боломжтой
Дунд зэргийн нөлөөлөл	Хэмжээ, тархалтын хувьд дунд зэрэг	Дунд хугацааны	Төсөл дууссанаас хойш 6 сараас 2 жилийн хугацаанд нөхөн сэргээгдэх боломжтой.
Томоохон нөлөөлөл	Хэмжээ, тархалтын хувьд их	Урт хугацааны	Төсөл дууссанаас хойш 2 ба түүнээс жилийн хугацаанд дараа нөхөн сэргээгдэх боломжтой
<b>S: хамрах хүрээ буюу газарзүйн тархалт</b>			
<b>Үнэлгээ= 1</b>	Нөлөөлөх талбай: зөвхөн төслийн талбайн хүрээнд		
<b>Үнэлгээ =2</b>	Нөлөөлөх талбай: төслийн талбайгаас гадагш 500м-ийн радиуст		
<b>Үнэлгээ =3</b>	Нөлөөлөх талбайн: 500м-ийн радиусаас цааш талбайг хамарсан		
<b>F: Давтамж буюу магадлал</b>			
<b>Үнэлгээ= 1</b>	Бага магадлалтай- Санал болгож буй төсөлтэй ижил төслүүдийн хувьд үүсэж байсан, энэ төслийн хувьд бараг тохиолдох боломжгүй		
<b>Үнэлгээ =2</b>	Дунд зэргийн магадлалтай - Энэ төслийн хувьд тохиолдох боломжтой		
<b>Үнэлгээ =3</b>	Өндөр магадлалтай - Энэ төслийн хувьд бараг л тохиолдоно		
Нийт түвшин= $M \times S \times F$	Үнэлгээ	Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хэмжээ	
<b>Нөлөөллийн түвшин бага</b>	<6	Бага - Тийм ч анхаарал татахуйц биш	
<b>Нөлөөллийн түвшин дунд</b>	6-18	Дунд - урьдчилан сэргийлж, нөлөөллийг бууруулж зохицуулах боломжтой	
<b>Нөлөөллийн түвшин өндөр</b>	>18	Их буюу өндөр - урьдчилан сэргийлж, нөлөөллийг бууруулж зохицуулах боломжтой	
<b>Бууруулж болохуйц нөлөөлөл: Нөлөөлөл нь их боловч тодорхой аргыг хэрэглэснээр нөлөөллийн түвшнийг бууруулах боломжтой.</b>			
<b>Үр дүнтэй (зэрэг нөлөөлөл): Нөлөөлөл нь их боловч байгаль орчин, хүний хэрэглээ, хүний үнэ цэнийг сайжруулж чадна</b>			

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийг газрын гадарга, уур амьсгал, агаарын чанар, дуу чимээ, усан орчин, хөрс, ургамал үзүүлэх байдлаар нь үнэлж, үр дүнг тодорхойлов.

**Хүснэгт 3. Агаарын чанарт нөлөөлөх байдлын үнэлгээний матриц**

№	Нөлөөллийн хэлбэр	Бохирдлын эх үүсвэр	Нөлөөллийн онооны үзүүлэлт								Нөлөөллийн түвшин
			Н	A <sub>1</sub>	A <sub>2</sub>	A <sub>3</sub>	B <sub>1</sub>	B <sub>2</sub>	C	Σ	
1	Тоосжилт	Машин техникийн ашиглалт	-1	1	1	2	1	1	1	-7	Бага
		Хог хаягдал	-1	1	1	2	1	1	1	-7	Бага
		Зам талбай	-1	1	1	2	1	1	1	-7	Бага
2	Хорт хий	Машин техникийн ашиглалт	-1	1	2	1	1	2	2	-9	Бага
3	Дуу шуугиан	Машин техник	-1	1	1	1	1	1	1	-6	Бага
4	Үнэр	Хог хаягдал	-1	1	2	2	1	2	1	-9	Бага
<b>Дүгнэлт</b>			Дээр дурдсан бүх нөлөөллүүд нь бага зэргийн нөлөөтэй байна.								

**Хүснэгт 4. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвчид нөлөөлөх байдлын үнэлгээний матриц**

№	Нөлөөллийн хэлбэр	Нөлөөллийн хэлбэр	Нөлөөллийг үнэлэх үзүүлэлт							Нөлөөллийн зэргийн шалгуур	
			Н	A <sub>1</sub>	A <sub>2</sub>	A <sub>3</sub>	B <sub>1</sub>	B <sub>2</sub>	C <sub>1</sub>		Σ
1	Боломжит нөлөөлөл	Бүтээн байгуулалтын явцад хөрс эвдрэлд өртөх, зулгарах, устах	-1	1	2	2	1	1	1	8	Бага
		Барилгын материалын тээвэрлэлтийн нөлөөгөөр шороон зам үүсэх	-1	1	2	2	1	1	1	8	Бага
		Ажилчидын түр байршихтай холбоотой хог хаягдал, орчны талхагдал үүсэх	-1	1	2	2	1	1	1	8	Бага
2	Сөрөг нөлөөлөл	Бүтээн байгуулалтын ажлын явцад талбай бэлтгэх зорилгоор хөрс хуулах, шимт хөрс хадгалах,	-1	1	2	3	1	1	1	8	Дунд
		Төслийн бүтээн байгуулалт болон цаашдын үйл ажиллагааны явцад хэврэг бүтэцтэй элсэнцэр харшороон хөрс талхагдалд өртөх	-1	1	2	3	1	1	1	8	Дунд
3	Хуримтлагдах нөлөөлөл	Төслийн үйл ажиллагаа эхлэх үед жуулчидын хөрс орчны доройтол үүсэх	-1	1	2	2	1	1	1	8	Бага
		Төслийн өдөр тутмын үйл ажиллагаанаас үүдэлтэй хог хаягдлаар хөрс бохирдох, хөрс эвдрэлд өртөх	-1	1	2	2	1	1	1	8	Бага
<b>Дүгнэлт</b>			Дурдсан нөлөөллүүдийн 70% нь бага буюу сул эрсдэлтэй бүсэд багтсан байна.								

**Хүснэгт 5. Гадаргын болон газрын доорх усанд нөлөөлөх байдлын үнэлгээний матриц**

№	Нөлөөллийн хэлбэр		Нөлөөллийг үнэлэх үзүүлэлт							Нөлөөллийн түвшин	
			Н	A <sub>1</sub>	A <sub>2</sub>	A <sub>3</sub>	B <sub>1</sub>	B <sub>2</sub>	C <sub>1</sub>		Σ
1	Гадаргын усны нөөц баялаг	Барилгын ажил	-1	1	1	2	2	1	1	-8	Бага
		Аялал жуулчлалын төслийн үйл ажиллагаа	-1	1	1	2	2	1	1	-8	Бага
2	Газрын доорх усны нөөц баялаг	Барилгын ажил	-1	1	1	2	1	1	1	-7	Бага
		Аялал жуулчлалын төслийн үйл ажиллагаа	-1	1	2	2	1	1	1	-8	Бага
3	Усны чанарын өөрчлөлт	Барилгын ажил	-1	1	1	2	1	1	1	-7	Бага
		Аялал жуулчлалын төслийн үйл ажиллагаа	-1	1	1	3	2	1	1	-9	Бага
4	Усны нөөцийн өөрчлөлт	Барилгын ажил	-1	1	2	1	1	1	1	-7	Бага
		Аялал жуулчлалын төслийн үйл ажиллагаа	-1	1	2	2	1	1	1	-8	Бага
<b>Дүгнэлт</b>			Дээр дурдсан бүх нөлөөллүүд нь бага зэргийн нөлөөтэй байна..								

**Хүснэгт 6. Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээний матриц**

Д/д	Болзошгүй нөлөөлөл	Нөлөөлөлд өртөгдөх талбай, нөлөөллийн хэлбэр	Нөлөөллийн түвшин		
			их	дунд	бага
1	Байгалийн ургамалжил устах	Аялал жуулчлалын цогцолбор байгуулах, түүнийг дагалдан бий болох бусад жижиг барилга байгууламжуудыг байгуулах, ашиглах зэргээс	x	-	-
2	Ургамлын ургах чадварыг алдагдуулах	Машин техникийн хөдөлгөөн, хог хаягдал ба шороо, тоосжилт нь ургамлан бүрхэвч дээр бууж хуримтлагдах	x	-	-
3	Урт үндэстэй, олон наст ургамалд нөлөөлөх	Бага гүний усны татралт нь гүний усаар тэжээгддэг ургамлын ургалт саарах, мөхөх улмаар ургамал нөмрөгийн доройтолд өртөх	x	-	-
4	Гадаргын устай холбоотой ургамалжил мөхөх	Хүчтэй аадар борооны гадаргын урсац, нэл угаагдлаар ургамлан нөмрөг бохирдох, ургамлан бүрхэц багасах, зүйлийн бүрэлдэхүүний тоо цөөрөх, улмаар ургамлан нөмрөг устаж болзошгүй	-	x	-

**Хүснэгт 7. Амьтны аймагт нөлөөлөх байдлын үнэлгээний матриц**

№	Нөлөөллийн хэлбэр	Нөлөөлөлд өртөгдөх талбай, нөлөөллийн хэлбэр	Нөлөөллийн түвшин		
			Их	Дунд	Бага
1	Амьтад үхэж хорогдох	Өнгөн хөрсийг хуулснаар мэрэгчид, мөлхөгчид болон сээр нуруутан амьтдын амьдрах орчныг сүйтгэх	x	-	-
2	Зарим зүйлийн шавж, сээр нуруугүйтэн амьтдын тоо буурах	Өнгөн хөрсийг хуулснаар үүдсэн экологийн нөхцөл байдлын өөрчлөлтөөс зарим зүйлийн шавжийн тоо толгой буурах, өсөн нэмэгдэж болзошгүй.		x	-
3	Зэрлэг амьтад ойр орчмоос дайжих	Дуу чимээ, гэрэлтүүлэг, тээврийн хэрэглэлийн хөдөлгөөн ба машин техникийн нөлөөгөөр	x	-	-
4	Мал, амьтан үхэж, үрэгдэх	нүх, суваг шуудуунд мал, амьтан унах	-	-	x
5	Мал, амьтны бэлчээр хомсдох	Зам барих үйл ажиллагаанаас малын бэлчээр, зэрлэг амьтдын амьдрах талбай хомсдох	-	-	x
6	Хууль бус ан агнах	Шинээр ирж ажиллаж, суурьших хүмүүс зэрлэг ан амьтдыг хууль бусаар агнах	-	-	x



## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАНИЛЦУУЛГА

“Дэгрээ Дөргөн” ХХК-ийн Говь-алтай аймгийн Хөх морьт сумын нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх “Баруун таван аймгийн аялал жуулчлалын цогцолбор” төслийн барилгажилтын үе шат болон үйл ажиллагаа эхлэх үед төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” Монгол Улсын хууль, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу хийж гүйцэтгэсэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд тулгуурлан холбогдох дүрэм, журамд нийцүүлэн боловсруулав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь:

1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
2. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

### **Байгаль орчныг хамгаалах, төлөвлөгөө**

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн харуулж буй төсөл хэрэгжүүлэгчийн заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг холбогдох журам, ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагын дагуу урьдчилсан байдлаар тодорхойлж тусгав. Эдгээр зардлууд нь байгаль орчныг хамгаалах ажлын шууд зардлууд ба түүнтэй холбогдох бусад зураг төслийн буюу туслах ажлуудын зардал ороогүй.

Энэхүү төлөвлөгөөнд тусгасан байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүд нь зөвхөн төслийн гүйцэтгэгч “Мандалт констракшн” ХХК нь Хэнтий аймгийн Дадал сумын нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх “Чингис хаан аялал жуулчлалын цогцолбор байгуулах” төслийг хэрэгжүүлэхэд зориулагдсан болно. Төслийн хүчин чадал өөрчлөгдөх, нэмэгдэх бүрд төлөвлөгөөнд нэмэлт тодотгол хийлгэж байх шаардлагатай. Мөн энэхүү БОХТ-ний ихэнх хэсэг Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөртэй нягт уялдах тул төслийн хэрэгжилтийн бүхий л хугацааны туршид газрын доорх ус, хөрсний чанар, ургамалжилт, амьтны аймагт гарч байгаа өөрчлөлтүүдийг тухай бүрд нь шинжилж, холбогдох арга хэмжээг жил бүрийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байх шаардлагатай.

Төсөл хэрэгжүүлэгч нь Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллах хэрэгтэй.

- БОХТ-ний хэрэгжилтийн талаарх тухайн жилийн хяналт, судалгаа шинжилгээгээр төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр, түүний ойр орчмын нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд дүгнэлт хийх ажлыг байгаль орчны хяналт шинжилгээний ажлын үр дүнгүүдэд үндэслэн хийх;

- БОХТ-ний биелэлтийг дүгнэхдээ тухайн жилийн хяналт, судалгаа шинжилгээгээр төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагуудын холбогдох хяналтын байцаагч нар, ард иргэдээс тавих шаардлага, хүсэлтийг хэрхэн хангасныг мөн авч үзэх;
- БОХТ-ний биелэлтийн үр дүнгийн жил бүрийн тайланг тухайн оны 11 дүгээр сарын 01-ны дотор Хэнтий аймгийн Байгаль орчны газар, Дадал сумын оршин суугчдад танилцуулж, тэднээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах;

### **Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр**

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь төслийн гүйцэтгэгч “Дэгрээ Дөргөн” ХХК-ийн Говь-алтай аймгийн Хөх морьт сумын нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх “Баруун таван аймгийн аялал жуулчлалын цогцолбор” төслөөс байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан баримт бичиг юм.

ОХШХ нь БОХТ-тэйгээ нягт уялдсан байх ба байгаль орчныг хамгаалах арга хэмжээний үр дүнг илэрхийлнэ. Мөн төслийн байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүд нь үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу төсөл батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор Байгаль орчин, аялал жуулчлалын яамд хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг төсөл хэрэгжүүлэгч хариуцах болно.

Иймд төслийн гүйцэтгэгч “Дэгрээ Дөргөн” ХХК /Захиалагч/, Байгаль орчны үнэлгээ, зөвлөх үйлчилгээ эрхэлдэг “Экологийн бүтээмж” ХХК /Гүйцэтгэгч/ хооронд байгуулсан гэрээний дагуу тус төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлангийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Монгол Улсын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай шинэчилсэн хууль, БОНХАЖ Сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны А-117 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт болон БОАЖ Сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А-618 тушаалын хавсралтын дагуу холбогдох дүрэм журмын шаардлагад нийцүүлж боловсруулав.

“Баруун таван аймгийн аялал жуулчлалын цогцолбор” төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал 23 710.0 мян.төг юм.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг барилгажилтын болон үйл ажиллагаа эхлэх үе шат гэж 2 хуваан зардлыг тооцлоо.

**Хүснэгт 8. БОМТөлөвлөгөөний зардлын задаргаа /мян.төг/**

№	Ажлын нэр	Зардал
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардал	20 310.0
2	Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн зардал	3 400.0
<b>2024 оны байгаль орчны менежмент төлөвлөгөөний НИЙТ ЗАРДАЛ</b>		<b>23 710.0</b>

**4.1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

**Хүснэгт 9. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний нийт зардал /мян.төг/**

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Нийт зардал
1	Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	6 700.0
2	Ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө	5110.0
3	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Түүх соёлын дурсгалыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1 000.0
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	6 500.0
7	Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал	1 000.0
<b>2024 оны Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нийт зардал</b>		<b>20 310.0</b>

#### 4.1.1. Байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагааны явцад үүсэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг тодорхойлон доорх хүснэгтэд тусгав.

**Хүснэгт 10. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал /мян.төг/**

№	Сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
<b>АГААР ОРЧИН</b>							
1	Төслийн бүтээн байгуулалтын үед хөрс тээврийн хөдөлгөөн ихсэж агаар дахь тоосжилт, PM2.5, PM10, CO, SO2, NO2 ихсэж орчны хүчилтөрөгчийн (O2) хэмжээ багасаж болно.	<ul style="list-style-type: none"> <li>Аялал жуулчлалын цогцолборын үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгсэл болон бага оврын цахилгаан хөдөлгүүрийн яндангаас гарах утааны бохирдуулагч зөвшөөрсөн норм хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд зориулалтын шүүлтүүр тавих, солих</li> <li>Утаа тортог их гаргадаг хуучирсан машин техникийг ашиглалтаас хасах</li> </ul>	Барилгын ажлын үед	Дотоод төлөвлөгөөгөөр		2024 он	<ul style="list-style-type: none"> <li>-MNS 17.5.1.21:1992 Авто тээврийн хэрэгслийн дуу чимээ. Дуу чимээний хүлцэх түвшин хэмжих арга</li> <li>-Агаарын тухай хууль,</li> <li>-MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага</li> <li>-MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшний хэмжээ</li> <li>- MNS 4585:2016 Агаарын чанар. Ерөнхий шаардлага</li> <li>- Монголын агаарын чанарын стандарт (MNS)-4585:98, MNS-3384:82, MNS-3383:1982</li> <li>Агаар мандал. Бохирдлын эх үүсвэр, нэр томъёо, тодорхойлолт</li> </ul>
		<ul style="list-style-type: none"> <li>Бүтээн байгуулалтын үед хөрс тээврээс үүсэх тоосжилтоос сэргийлж тээврийн замыг тогтмол услах</li> </ul>					
		<ul style="list-style-type: none"> <li>Барилгын ажлаас гарсан хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт зөөвөрлөн аваачиж хаях</li> </ul>	Үйл ажиллагааны бүхий л үе шатанд	ОХШХ-т тусгагдсан.	2024 он		
		<ul style="list-style-type: none"> <li>Төсөл хэрэгжих хугацаанд мэргэжлийн байгууллагаар агаарын сорьц авхуулан шинжилгээ хийлгэж, зөвлөгөө авч байх</li> </ul>	Үйл ажиллагааны үед	Хог хаягдлын менежментэд тусгагдсан.	2024 он		
2	Хог хаягдлыг удаан хадгалснаас үнэр гарах	<ul style="list-style-type: none"> <li>Хог хаягдлын цэг дээрх хогийг тогтмол ачиж зайлуулах</li> </ul>	Үйл ажиллагааны үед	Хог хаягдлын менежментэд тусгагдсан.		2024 он	
<b>ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧ, УРГАМЛАН НӨМРӨГ</b>							
3	Тээврийн хэрэгслийн явалт, хөрс эвдрэх, ургамал гэмтэх, эвдрэл үүсэхээс	<ul style="list-style-type: none"> <li>Төслийн талбайн тэмдэгжүүлэх, ногоон байгууламжтай хэсгээр амрагч, жуулчдыг зорчуулахгүй байх арга хэмжээг авах</li> </ul>		500.0	500.0	2024 он	<ul style="list-style-type: none"> <li>- MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн</li> </ul>
				Ногоон байгууламж байгуулах арга хэмжээнд тусгагдсан.		2024 он	

	гадна хог хаягдал, бохирын шингэн алдагдсанаас хөрсөнд бохирдол үүсэж болзошгүй	<ul style="list-style-type: none"> <li>Орчныг тохижуулах, мод бут /жимс, жимсгэнэ, чацаргана г.м/ тарих</li> <li>Газар ашиглалт, хөрсний бохирдолд нөлөөлж буй нөлөөлөл байгаа эсэхийг тодорхойлох, БОХШХ-т хамруулах</li> <li>Төслийн талбайн орчмын хөрсний бохирдлыг тодорхойлох хяналт-шинжилгээ хийх</li> </ul>	Үйл ажиллагааны үед	БОХШХ-т тусгагдсан.	2024 он	<p>зөвшөөрөгдөх дээд хэмжээ</p> <p>- MNS 5342:2007 “Автомашини зогсоол, ангилал, ерөнхий шаардлага”</p> <p>УСТ 3298-91 Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм</p> <p>- УСТ 328-91 Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд</p> <p>MNS 5918-2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрын ургамалжуулахад тавигдах шаардлага</p>
4	Хатуу хог хаягдлыг тогтмол ачуулах, хог хаягдлын цэгийг засаж тохижуулах	<ul style="list-style-type: none"> <li>Хог хаягдлын цэгийн төлөвлөх, зориулалтын ангилан ялгах хогийн сав байршуулах</li> </ul>	Үйл ажиллагааны үед	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан.	2024 он	
	Төслийн барилга байгууламж барих түүхий эд ачиж буулгах явцад тоосжилт үүснэ. Дээрх үүссэн тоосжилтоос трассын ойр орчмын ургамлан нөмрөгийн морфологид өөрчлөлт орох, фотосинтезийн эрчим буурах	<ul style="list-style-type: none"> <li>Хөх морьт сумаас төслийн талбай хүртэл түүхий эд тээвэрлэх явцад үүсэх байнгын тоосжилтыг уг Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний 1.1-т тусгасан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Ургамлан нөмрөгийн мониторингийн ажлыг жил бүр тогтмол явуулж, нөлөөллийг тогтоож бууруулах</li> </ul>	Төслийн талбайн орчим	Хяналт шинжилгээний хөтөлбөрийн ургамлан нөмрөгийн хэсэгт тооцсон.	2024 он	
	ШТМ алдагдах, асгарч, нэвчих нь хөрсийг богино болон удаан хугацаанд бохирдуулснаас ургамлан нөмрөг бохирдож устаж болзошгүй	<ul style="list-style-type: none"> <li>БОХТ-ний хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах (Уг байгаль хамгаалах төлөвлөгөөний 5.1-т тусгасан) арга хэмжээг авч хэрэгжүүлэх</li> </ul>	Засварын газрууд болон бусад	Үйл ажиллагааны зардалд тусгах.	2024 он	
	Төслийн барилга байгууламж барих түүхий эд ачиж буулгах явцад тоосжилт үүснэ. Дээрх үүссэн тоосжилтоос ойр орчмын ургамлан нөмрөгийн	<ul style="list-style-type: none"> <li>Бэлчээрийн менежмент тодорхойлж ургамлын шууд болон шууд бус нөлөөгөөр доройтсон нь тогтоогдвол тэдгээрийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх</li> </ul>	Төслийн талбай орчны бүсэд	2 000.0	2024 он	

	морфологид өөрчлөлт орох, фотосинтезийн эрчим буурах						
<b>УСАН ОРЧИН</b>							
5	Бохир ус агуулах, хадгалах байгууламжуудын ус үл нэвчүүлэх хамгаалалт хагарах, цоорох, бохир ус дамжуулах хоолойд гэмтэл үүсэх зэрэг нь бохирдлын эх үүсвэр болно.	✚ Хог хаягдлын цэгийг урсац хөрсөнд нэвчихээргүй болгож засаж янзлах, бетон суурийн хамрах хэмжээг нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны үед	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан		2024 он	<ul style="list-style-type: none"> <li>- MNS 13.060.50 Усны чанарын стандарт</li> <li>- Усны тухай хууль</li> <li>- 2.3.5 хавсралт,</li> <li>- MNS 4943:2015 Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага</li> </ul>
		✚ Бохир усны шугам хоолой, түүхий эдийн ил задгай агуулах, хатуу хаягдлаас үүсэх урсац хөрсний усанд нэвчих, угаалга цэвэрлэгээнээс гарсан бохир усыг ил задгай асгах зэргээр хөрсний усны чанарт нөлөөлөхөөс сэргийлэх		Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгасан.			
		✚ Ахуйн бүх төрлийн бохир ус дамжуулах хоолойн холбооснуудаар ус алдагдаж байгаа эсэхийг үе үе хянах боломжтой тоноглох, хянаж байх		Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгасан.			
		✚ Цэвэр ус цэвэрлэх байгууламжид туршилт, тохиргоо хийлгэх		500.0			
<b>АМЬТНЫ АЙМАГ</b>							
	Төслийн үйл ажиллагааны явцад болон бүс нутгийн ховор ан амьтад дайжих	Ховор ан амьтдын нүүдэл шилжилтийн хөндлөн гарах газруудыг тодорхойлж ховор ан амьтад нөлөөллөх нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх	Төслийн талбайн нутаг дэвсгэрт хамаарах талбай тэдгээрийн орчны бүсэд	3 000.0		2024 он	<ul style="list-style-type: none"> <li>- MNS 5915:2008 Эвдэрсэн газрын ангилал</li> <li>- MNS 5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт</li> </ul>
	Салаа зам гарснаас бэлчээрийн чанар доройтох, талхлагдах	Замын мэдээллийг (хуучин, шинэ) улирал бүр бүртгэж шинэчлэн зураглаж, холбогдох арга хэмжээ авахдаа ашиглах	Төслийн нөлөөллийн бүсэд	500.0	500.0	2024 он	

6	Автомашин, тээврийн хэрэгслийн дуу чимээнээс ан амьтан үргэж дайжих, байршил тархалт нь өөрчлөгдөх, амьтдын амьдрах орон зай нь хумигдах, аялал жуулчлалын баазын үйл ажиллагааг дагалдаж хууль бусаар урхи, занга тавьж ан амьтан агнах, амьтны нөөц хорогдох, амьдрах орчин нь өөрчлөгдөх эерэг сөрөг нөлөөтэй.	Амьтад дайжиж үргэхээс болгоомжилж хүчтэй дуу чимээ гаргахгүй байхад анхааруулах	Үйл ажиллагааны үед	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгасан.		2023-2027 онуудад
		Аялал жуулчлалын баазын нутаг дэвсгэрт ан амьтны амьдрах орчныг бусниулахгүй, үргээхгүй алж устгахгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх		Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгасан.		
		Ан амьтны тоо толгой, байршил, тархалтыг тогтоож, тэдгээрийг хамгаалах арга хэмжээ авах, холбогдох хууль тогтоомжийг сурталчлах		200.0	200.0	
<b>2024 оны Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний нийт зардал</b>						<b>6 700.0</b>

#### **4.1.2. Нөхөн сэргээлт, ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө**

Төсөл хэрэгжүүлэгч нь эзэмшлийн талбайн өнгө үзэмж, тоосжилтыг бууруулах зорилгоор салхины дээд талд ногоон байгууламж байгуулах, суулгаж буй мод бутны ургалт, өсөлтийг нэмэгдүүлэх, ургах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд мод бут суулгасан хөрсийг бордох, сайжруулах, ногоон байгууламжийг арчлах, гадаад үзэмжид нөлөөлөх цэцгийн мандал байгуулах, сукцесст орсон хэсгийг нөхөн сэргээх ажлыг хийх ёстой хэдий ч төслийн талбайн 80 гаруй хувь нь байгалийн ногоон байгууламжтай байгаа ба төсөл хэрэгжүүлэгч төслийн талбайд ногоон байгууламж байгуулах шаардлагатай байна. Иймд манай зөвлөх баг тус ногоон байгууламжийн арчилгаа, тордлогоо, усалгааны зардлыг тооцлоо. Үүнд:

1. Төслийн барилгын ажлын үед сүйдсэн бутны суулгац суулгах талбайн хөрсийг бордох, хөрсний чанарыг сайжруулах
2. Амрагчдын амрах, тухлах орчинтой холбоотойгоор ногоон байгууламж, цэцгийн мандал төлөвлөхдөө цэцэрлэгжүүлэлтийн чиглэлийн мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авах, мэргэжлийн хүмүүсийн тусламжтай мод суулгац тарьж ургуулах
3. Ногоон байгууламжийн ургалтад анхаарал, хяналт тавих, усалгаа, тордлогоо байнга хийх, хүнд машин механизм болон хүний үйл ажиллагаагаар хугарч гэмтэх, халцарч, зулгарахаас хамгаалах арга хэмжээг авах, ногоон байгууламжийн орчимд хаалт, хамгаалалт тавих



**Хүснэгт 11. Нөхөн сэргээлт, ногоон байгууламж байгуулах төлөвлөгөөний зардал /мян.төг/**

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Нэгж зардал	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
2	Ерөнхийлөгчийн санаачилсан “Нэг тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд ногоон төгөл байгуулах	Төслийн талбайн онцлогт тохиромжтой ногоон төгөл байгуулах	Төслийн талбайд	1 000.0	1 000.0	2024 он	- MNS 6263:2011 Цэцэрлэгжүүлсэн талбайг шалгаж, ашиглалтад хүлээн - авах. Ерөнхий шаардлага
1	Төслийн талбайн ногоон байгууламжийг нөхөн сэргээх, халцарч зулгарсан, сукцесст орсон хэсгийг тарималжуулах	Ургалтад анхаарал, хяналт тавих, тордлогоо байнга хийх, арга хэмжээг авах, ногоон байгууламжийн орчимд хаалт, хамгаалалт тавих/	Ногоон байгууламжийн орчимд	268.0	268.0	2024 он	- MNS 5994:2009 Мод, сөөгний үр. Тариалалтын чанар. Техникийн шаардлага
		Усалгаа		342.0	342.0	2024 он	MNS 6253-2:2011 Мод, сөөгний үр тарих. Ерөнхий шаардлага
		Мэргэжлийн зөвлөгөө		1 000.0	1 000.0	2024 он	MNS 5918:2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрыг
		Нөхөн сэргээлт	Эвдэрсэн газрын орчимд	-	2 500.0	2024 он	ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага. Хамрах хүрээ
<b>2024 оны нөхөн сэргээлт, ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө Нийт зардал (мян.төг)</b>						<b>5 110.0</b>	

#### **4.1.3. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө**

Тухайн төслийн бүсэд зайлшгүй нүүлгэх шаардлагатай иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй болно.

#### **4.1.4. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө**

Төсөл хэрэгжих бүс нутагт барилгын ажил эхлэхээс өмнө археологи, палеонтологийн судалгаа хийлгээ, археологи палеонтологийн олдвор илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагад мэдэгдэх шаардлагатай.

#### 4.1.5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

“Баруун таван аймгийн аялал жуулчлалын цогцолбор” төслийн барилга байгууламжийн барих үеийн осол эрсдэлийн тухай Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн Бүлэг 4. Эрсдэлийн үнэлгээ, менежмент, ХАБЭА-д тодорхойлон тусгаж өгсөн. Тус аялал жуулчлалын цогцолбор барьж байгуулах үйл ажиллагаа нь барилгажилтын болон үйл ажиллагаа эхлэх 2 үе шатнаас бүрдэх тул барилгажилтын үе шатанд барилгын материал болон барилгын хог хаягдлыг тээвэрлэх, ачиж буулгах үеийн осол эрсдэл, барилга байгууламжийн барих угсрах үеийн осол эрсдэл өндөр байгаатай холбогдуулж ажилчдыг осол эрсдэлээс хамгаалах арга хэмжээний зардлыг төлөвлөлөө.

**Хүснэгт 12. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал /мян.төг/**

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Арга хэмжээний цар, хүрээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Зун, намрын улиралд үргэлжилсэн буюу их устай борооны улмаас аялал жуулчлалын цогцолборын талбайд ихээхэн хэмжээний ус цутган орсноос ослын байдал гарч болно.	Үйл ажиллагааны үед		Дотоод төлөвлөгөөгөөр	2024 он	MNS 6010:2009 Гамшгийн холбогдолтой нэр томьёо, тодорхойлолт, ерөнхий анги
2	Хүчтэй салхи шуурга, газар хөдлөлт, аянга цахилгаан буух үед амрагчид болон ажиллагчид бэрхшээл учруулж болзошгүй.	Үйл ажиллагааны үед		Дотоод төлөвлөгөөгөөр	2024 он	MNS 4244:1994 Хөдөлмөр хамгааллын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага
3	Ажлын байрны эрүүл ахуйн нөхцөлийг хангаагүйгээс ажиллагсад болон үйлчлүүлэгсдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх	Үйл ажиллагааны үед	500.0		2024 он	MNS 5390:2004 Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага
4	<i>Бохир усны цооног, бие засах газарт ариутгал халдваргүйжүүлэлтийг хийгээгүйгээс</i> ажиллагсад болон үйлчлүүлэгсдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх	Үйл ажиллагааны үед		Дотоод төлөвлөгөөгөөр	2024 он	Улсын онцгой комисс даргын 2021 оны 18 дугаар тушаалын хавсралт Коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам /Амралтын газар, жуулчны бааз, зочид буудал, дэн буудлын үйл ажиллагаанд тавигдах тусгай нөхцөл шаардлага
5	Байр сууцны ойр орчимд байгаль орчинтой зөв зохистой харьцах тухай санамжуудыг байрлуулах ба экологийн боловсролын хэсэг, булан байрлуулах	Үйл ажиллагааны үед	500.0		2024 он	
<b>2024 оны осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний нийт зардал</b>						<b>1 000.0</b>

#### 4.1.6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын менежмент гэдэг нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хог хаягдлаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор хог хаягдлын эх үүсвэрийг бууруулах, ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах бүхий л процессыг хянаж сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ юм.

Төсөл хэрэгжүүлэгч нь хог хаягдлын менежментийн хүрээнд цаашдын авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, хог хаягдлыг газар дээр нь ангилан ялгах нөхцөл бололцоог хангаж ажиллах үүрэгтэй.

Эзэмшил газрынхаа ойр орчны цэвэрлэгээг тогтмол хийх, үйл ажиллагааны явцад үүсэх хог хаягдлыг тогтоосон цэгт хуримтлуулж тогтмол хугацаанд зайлуулах, ангилан ялгаж дахин ашиглах боломжтой хаягдлыг ашиглах, аливаа зүйлээр бохирдсон хог хаягдлыг саармагжуулах, галын аюулаас хамгаалах, хадгалалт хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хадгалахдаа хогийн сав болон хогийн цэгийг өнгөөр ялгаж зургаар тэмдэгжүүлснээр хуурай хог хаягдлыг стандартын дагуу ачиж, тээвэрлэх хадгалах нөхцөл бүрдэхээс гадна байгаль орчинд сөрөг нөлөөгүй бохирдолгүй амьдрах нөхцөл бололцоо бий болох юм.


Хатуу хог хаягдлаа ялган ангилсны ач холбогдол:

- ✓ Цаас, шил, мод, яс, хуванцар, металл, органик гаралтай хаягдлыг эргүүлэн ашиглах, дахин боловсруулах боломж бий болно.
- ✓ Орчныг бохирдуулах, устгал хийх хогны хэмжээ эрс багасна.
- ✓ Хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр ачиж тээвэрлэх боломж бүрдэнэ.
- ✓ Хүн амын аюулгүй, цэвэр, эрүүл орчинд ажиллах, амрах нөхцөл бүрдэнэ.
- ✓ Амьтан, ургамал, хөрс, усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл багасах зэрэг олон талын ач холбогдолтой юм.

КЦС-ын төслийн үйл ажиллагаанаас хатуу, шингэн хог хаягдал, болон барилгажилтын үе шатанд барилгын хог хаягдал гарах ба үүнээс хатуу хог хаягдлыг ахуйн болон аюултай хог хаягдал хэмээн ялгаж тус бүрд нь тохирсон арга хэмжээг авч ажиллана.

#### **Энгийн хог хаягдлын менежмент**

Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн талбайд Хог хаягдлын цэгийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 17 өдрийн А/443 дугаар тушаалын хавсралт “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”-ын дараах заалтын дагуу барьж байгуулан ашиглах шаардлагатай.



Зураг 4 Хог хаягдлын цэгийн шийдэл

Төслийн талбайд байгуулах Хог хаягдлын цэгийг Зураг 31-д заасны дагуу битүүмжлэлтэй, цоожтой лист төмрөөр хийгдсэн байхаар хийх боломжтой ба хог хаягдлыг энгийн, дахивар, аюултай хог хаягдал зэрэг 3 ангилан ялгах нь зүйтэй.

**Хүснэгт 13. Ангилан ялгах хог хаягдлууд**

Энгийн хог хаягдал	Дахивар хог хаягдал	Аюултай хог хаягдал
<ul style="list-style-type: none"> <li>✓ Хоолны үлдэгдэл;</li> <li>✓ Хүнсний ногоо, жимсний хальс, үлдэгдэл;</li> <li>✓ Яс;</li> <li>✓ Хэрэглэсэн хүнсний тос</li> <li>✓ Аюултай болон дахин боловсруулах хог хаягдлаас бусад хог хаягдал</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Цаас /хэт бохирдоогүй сонин, сэтгүүл, дэвтэр, бичгийн цаас, төрөл бүрийн боодлын цаас, картон цаас, сүү, жүүсний тетрапак савлагаа/</li> <li>✓ Хуванцар /төрөл бүрийн ус, ундааны хуванцар сав, 0,025 мм-ээс дээш зузаантай гялгар уут, баглаа боодол кетчуп, ургамлын тос, бие угаагч шингэн, шампунь, угаалгын шингэний хуванцар сав, гм/</li> <li>✓ Хөнгөн цагаан, төмөр, метал, зэс, гууль, тэдгээрээр хийсэн зүйл;</li> <li>✓ Шил /хүнсний болон бүх төрлийн шилэн сав, шилэн эдлэл/;</li> <li>✓ Лааз;</li> <li>✓ Мод, модон эдлэлийн хаягдал;</li> <li>✓ Хувцас, даавуун эдлэл;</li> <li>✓ Савхи, резин;</li> <li>✓ Өвс, мод.</li> </ul>	<p>Аюултай хог хаягдал гэж амьтан, ургамлыг өвчлүүлэх, гэмтээх, тэдгээрийн үр удамд хор хөнөөл учруулах болон байгаль орчны хэвийн төлөв байдалд сөрөг нөлөөтэй хортой, идэмхий, исэлдүүлэгч, шатамхай, дэлбэрэх хог хаягдлыг хэлнэ. Иймд төслийн талбайн машин засварын цехийн үйл ажиллагаанаас гарч буй нефть болон газрын тосны бүтээгдэхүүн агуулж буй сав, савны цэвэрлэгээнд ашигласан цэвэрлэгээний материал, тос тосон бүтээгдэхүүн агуулж буй савны хаягдлыг энэ цэгт төвлөрүүлж Хог хаягдал тээвэрлэх машинд ачуулж тусгай цэгт хүргүүлнэ.</p>

**Хог хаягдлыг цуглуулахад тавигдах ерөнхий шаардлага**

**2.3.1. Энгийн хог хаягдлыг цуглуулах гэж Хог хаягдлын тухай хуулийн 4.1.8-д заасныг ойлгох ба хуулийн 14 дүгээр зүйлд зааснаас гадна энэхүү тавигдах ерөнхий шаардлагын 2.3.2-2.3.5-д заасан ерөнхий шаардлага хамаарна.**

**2.3.2. Хог хаягдлын тухай хуулийн 14.2-т заасан гэрээнд хог хаягдал цуглуулах төрөл, хэлбэр, хогийн цэгийн байршил, ажиллах цагийн хуваарь, орчны тохижилт, ариун цэврийн шаардлагын талаар тодорхой тусгасан байна.**

**2.3.3. Хог хаягдлыг цуглуулах зориулалт бүхий сав, төхөөрөмж гэж энгийн хог хаягдлыг тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах зорилгоор хог хаягдлыг цуглуулж байгаа хог хаягдал үүсгэгчийн ойролцоо байршуулсан савыг хэлэх ба дараах ерөнхий шаардлага хангасан байна.**

- а. Хог хаягдал цуглуулах сав, төхөөрөмжийг сум, хорооны Засаг даргын зөвшөөрсөн хэлбэр, хэмжээ, зориулалт болон заасан газарт байгуулна.
- б. Орон сууцны хороолол, нийтийн эзэмшлийн талбай, явган хүн, авто машины хөдөлгөөнд саад учруулахааргүй газар байна.
- в. Хог хаягдал хийсэх, агаар болон хөрсөнд тархах, шингэх, уусах, үнэр тархахгүй нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- г. Хог хаягдлын төрөл, ангиллын мэдээллийг ил харагдахуйц байршуулсан байна.
- д. Байгаль орчинд сөргөөр үл нөлөөлөх нөхцөлөөр буюу чанарын шаардлага хангасан байна.
- е. Тээвэрлэх зориулалт бүхий уяа, дэгээтэй, хог хаягдал ачих тээврийн хэрэгсэлд зориулагдсан байна.

ж. Хог хаягдал цуглуулах зориулалт бүхий сав, төхөөрөмжийн хог хаягдал хадгалах, цуглуулах багтаамж 3 хоногоос ихгүй байна.

**2.3.4.** Хог хаягдал цуглуулах иргэн, аж ахуй нэгж, байгууллагын ажилтан нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна.

а. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зохих мэдлэгтэй байх;

б. Хөдөлмөр хамгааллын нэг бүрийн хэрэгсэл хэрэглэх;

в. Хог хаягдал цуглуулах үйл ажиллагааны бүрэн мэдлэгтэй, хог хаягдал үүсгэгчийн онцлогийг тодорхойлох чадвартай байх.

**2.3.5.** Хог хаягдлын цуглуулахдаа ангилан ялгасан хог хаягдал тус бүрээр цуглуулна.

### **Хог хаягдлын менежмент**

Төслийн барилгажилтын үе шатанд авто машины засвар үйлчилгээнээс гарч буй нефть болон газрын тосны бүтээгдэхүүн агуулж буй сав, савны цэвэрлэгээнд ашигласан цэвэрлэгээний материал, тос тосон бүтээгдэхүүн агуулж буй савны хог хаягдал гарна. Иймд тус хог хаягдлын менежментийг дараах байдлаар зохицуулна.

- ✚ авто машины засвар үйлчилгээнээс гарах хог хаягдлыг Хөхморьт сумын ЗДТГ-тай хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулах, Хог хаягдал тээвэрлэх машинд ачуулж тусгай цэгт хүргүүлнэ.

Барилгын материалын хог хаягдлыг Хөхморьт сумын ЗДТГ-тай хог хаягдлын гэрээ байгуулан сумын хогийн цэгт тээвэрлэн аваачна.

**Хүснэгт 14. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал /мян.төг/**

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг өөрийн үйл ажиллагаанд тохируулан боловсруулж батлуулах, хэрэгжүүлж ажиллах.	Хог хаягдлын менежмент хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны туршид	Үйл ажиллагааны бүх хугацаанд			
2	Хогийг ангилах ялгах, цэгийг сайжруулах, байнгын арчилгаа тордолт хийх, талбайн зонхилох салхины доод талд багтаамж сайтай хогийн сав байршуулах, ангилан ялгах тэмдэг тэмдэглэгээтэй болгох, ажилчид үйлчлүүлэгчид хог хаягдлаа ил задгай хаяхгүй байхыг анхааруулсан самбар, тэмдэг тэмдэглэгээ байршуулах.	Хог хаягдлын менежмент хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны туршид	-	5 000.0	2024 он	Хог хаягдлын тухай хууль, эрүүл ахуйн тухай хуулийн 4.4.3 зүйл, 13.1.6 зүйл, Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх, тайлагнах журам
3	Талбай болон ажлын байрыг тогтмол цэвэрлэж байх. Ажилчдыг цэвэрлэгээний бодис хэрэглэлээр байнга хангаж байх хэрэгтэй.	Хог хаягдлын менежмент хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны туршид	1 000.0	1 000.0	2024 он	
4	Төслийн хэрэгжих талбайн 500м радиуст тогтмол цэвэрлэгээ хийх	Хог хаягдлын менежмент хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны туршид	500.0	500.0	2024 он	
4	Хог хаягдлыг тогтмол хугацаанд тээвэрлэж хаяж байх	Хог хаягдлын менежмент хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны туршид	Гэрээ байгуулах			
<b>2024 оны хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний нийт зардал</b>						<b>6 500.0</b>	

#### 4.1.7. Удирдлага, зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ

Төслийн хэрэгжилтийн үед авч хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын асуудал ихээхэн чухал үүрэгтэй юм. Удирдлага зохион байгуулалтын менежментийг дараах чиглэлд хандуулан төлөвлөгөөндөө тусгах нь зүйтэй.

- ✓ Байгаль орчны асуудал хариуцаж ажиллах ажилтан албан хаагч, түүний үүрэг хариуцлага
- ✓ Байгаль орчны чиглэлээр орон нутгийн иргэд, олон нийттэй хамтран ажиллах ажлын чиглэл
- ✓ Ажилтан албан хаагчдын дунд зохион байгуулах сургалт, танилцуулгын ажил, мэдээллийн самбар
- ✓ Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны чиглэлээр хийгдэх ажил
- ✓ Байгаль орчин хамгааллын чиглэлээр хийгдэх хяналт, шалгалтын хуваарь, бүртгэл хөтлөх, түүнийг хариуцах үүрэг хариуцлагын систем
- ✓ Байгаль орчин хамгааллын чиглэлээр бусад байгууллагатай хамтран ажиллах ажлын төлөвлөгөө, хуваарь
- ✓ Байгаль орчин хамгааллын чиглэлээр хийгдэх ажлын төсөв санхүүгийн зохицуулалт
- ✓ Эдгээр ажлуудыг хариуцан гүйцэтгэх байгаль орчны мэргэжилтэн ажиллуулах

Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр: Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулж батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллах, жилийн эцэст БОМТ-ний хэрэгжилтийг Хэнтий аймгийн БОГ-аар дүгнүүлэх, оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах, байгаль орчны хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор компанийнхаа дотоод дүрэм, журамд өөрчлөлт оруулах, Онцгой байдлын газар /ОБГ/, Мэргэжлийн хяналтын газар /МХГ/ зэрэг байгууллагуудаар ЧХАЖЦ-ын үйл ажиллагаанд хяналт тавиулж, хамтран ажилчдынхаа дунд галын аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын сургалтуудыг зохион байгуулах, осол эрсдэлээс хамгаалах ажлыг зохион байгуулах шаардлагатай.

Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах ажлууд:

Төслийн ажилчид, албан хаагчдыг үр бүтээлтэй, осол авааргүй ажиллуулах тулд Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны арга хэмжээг цаг тухай төлөвлөн, ажиллагсдад улирал бүр зааварчилгаа өгүүлэх, үе шаттайгаар хянан шалгах арга хэмжээнүүдийг өөртөө багтаасан Компанийн Хөдөлмөр Хамгаалал, Аюулгүй Ажиллагааны (ХХАА) системийг бий болгож түүн дээр үндэслэн, олон улсын болон Монгол улсын холбогдох хууль тогтоомжуудын шаардлагуудад нийцсэн журам стандартуудыг харьяалагдах байгууллагуудтай хамтран боловсруулж, батлуулан (Монгол улсын засгийн газраас 2005 онд баталсан ХХАА, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний хөтөлбөрийн 2.1.4, 2.1.6 заалтад тулгуурлан) мөрдөж ажиллах нь төсөл хэрэгжүүлэгчийн үүрэг юм.



Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр ажилчдад ажлын байрны онцлог тус бүрд нийцсэн ажлын хувцас хэрэгслийг олгох, хортой нөхцөлд ажилладаг ажилтанд хор саармагжуулах бүтээгдэхүүнийг ажлын байранд тогтмол олгох, жил бүр эрүүл мэндийн төвтэй хамтран нийт ажиллагсдаа эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулан, нарийн мэргэжлийн эмч нараар ажил, мэргэжлийн онцлогоос шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх сургалт, зөвлөгөө өгүүлэх, шаардлагатай тохиолдолд ажилтнуудыг амбулаториор эмчилгээнд хамруулах, машин тоног төхөөрөмж дээр ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг байрлуулж, ажилд гарахын өмнө ажиллагсдад аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгөх, ажлын байранд яаралтай үед хэрэглэх түргэн тусламжийн багаж хэрэгсэл, эм тариа бэлтгэх ажлуудыг төлөвлөлөө.

**Хүснэгт 15. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний зардал /мян.төг/**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцагч	Баримтлах стандарт, аргачлал
<b>1. Хуулийн хэрэгжилтийг хангуулах</b>						
1	БОМТ-д тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг тодорхой албан тушаалтанд хариуцуулан үйл ажиллагааг зохион байгуулах, дотоод журам тогтоож мөрдөх	Дотоод зардал		2024 он	Удирдлага	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 31.7 дугаар заалт
2	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих хугацаанд нь хийж гүйцэтгэх ба биелэлтийг жил бүр дүгнэж, дүнг байгаль орчны хяналтын байгууллагад хүргүүлж байх	Дотоод зардал		2024 он	ХАБЭА	“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 14.1.2-р заалт
3	Хог хаягдлын тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, хог хаягдлыг аль болох дахин ашиглах, дахин боловсруулах /гэрээ байгуулах/	Дотоод зардал		2024 он	ХАБЭА	“Хог хаягдлын тухай” хуулийн шинэчилсэн найруулга, 2017
<b>2. Ажиллагсдыг чадавхжуулах</b>						
4	Ажилчдыг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтад тогтмол хамруулах, чадавхжуулах		500.0	2024 он	Удирдлага	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуулийн 27.3.4, 28.1.8-р заалт “Химийн хорт болон аюултай бодисын тухай”
5	Шаардлагатай үед хэрэглэх иж бүрэн эмийн санг заавартай нь байрлуулах, тогтмол хугацаанд нөхөн сэлбэх	500.0	500.0	2024 он	ХАБЭА	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийн 14-р зүйл
<b>2023-2027 оны удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний нийт зардал</b>						<b>1 000.0</b>

## 4.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 16. Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр /мян.төг/

Бүрэлдэхүүн хэсэг	Дээж авах цэг	Мониторинг хийх үзүүлэлтүүд	Давтамж	Нэгжийн өртөг	Нийт зардал	Баримтлах стандарт ба аргачлал
Агаарын чанар	Аялал жуулчлалын цогцолборын салхины зонхилох чигийн доод хэсэг, хог хаягдлын цэгийн орчимд	<ul style="list-style-type: none"> <li>Тоосжилт (PM<sub>10</sub>, PSM, PM<sub>25</sub>)</li> <li>Бохирдлын цэгэн эх үүсвэр (O<sub>2</sub>, SO<sub>2</sub>, NO<sub>2</sub>, CO)</li> </ul>	Жилд 2 удаа	250.0	500.0	<ul style="list-style-type: none"> <li>MNS3113:1981. Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага</li> <li>MNS0017-2-3-16:1988. Агаар мандал-Хот суурины агаарын бохирдлын шинжилгээ</li> <li>MNS3384:1982. Агаар мандал-Агаарын дээжлэлт шинжилгээ</li> </ul>
Хөрсний чанар	Хог хаягдлын цэгийн орчимд	<ul style="list-style-type: none"> <li>Хөрсний үе давхаргын зузаан (см), элэгдэл эвдрэлийн нөхцөл, ялзмагийн агууламж, нийт азот, карбонат, Ca, Mg, P<sub>2</sub>O<sub>5</sub>, K<sub>2</sub>O, хөрсний pH, давсжилт, чийгшил</li> <li>Pb, As, Cd, Hg, Cu, As, Zn, Se –ийн агууламж</li> </ul>	Жилд 2 удаа	150.0	300.0	<ul style="list-style-type: none"> <li>MNS3985:1987. Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл</li> <li>MNS3310:1991. Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох</li> <li>MNS2305:1994. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам</li> <li>MNS(ISO)4814:1999. Атом шингээлтийн спектрометрээр шинжилгээ хийх</li> </ul>
	Бохир ус цэвэршүүлэх төхөөрөмжийн орчимд					
Усны чанар	Гүний худаг	<ul style="list-style-type: none"> <li>Усны pH, цахилгаан дамжуулах чадвар нүүрстөрөгчийн исэл CO<sub>3</sub>, хүчил HCO<sub>3</sub><sup>-</sup>, кальци Ca<sup>2+</sup>, хлор Cl<sup>-</sup>, кали K<sup>+</sup>, магни Mg<sup>2+</sup>, сод Na<sup>+</sup>, хүхэр S, хүнцэл As, бор B, бари Ba, кадми Cd, кобальт Co, хром Cr, зэс Cu, төмөр Fe, мөнгөн ус Hg, манган Mn, молибден Mo, никель Ni, хар тугалга Pb, селени Se, силикон Si, ванади V, цинк Zn, хөнгөн цагаан Al, мөнгө Ag</li> </ul>	Жилд 2 удаа	300.0	600.0	<ul style="list-style-type: none"> <li>MNS0900:1992. Ундны ус-Ундны усны хяналт-шинжилгээ</li> <li>MNS3935:1986. Ундны ус-Усны шинжилгээнд тавигдах шаардлага</li> <li>MNS3936:1986. Ундны ус болон үйлдвэрийн ус-Тухайн талбарт шинжилгээ хийх</li> <li>MNS4432:1997. Ундны ус. Хуурай үлдэгдлийн хэмжээг тодорхойлох</li> <li>MNS3934:1986. Ундны болон үйлдвэрийн ус-Химийн шинжилгээ хийх-Дээж авах, хадгалах, зөөвөрлөх</li> <li>MNS5667-10:2001. Усны чанар-Дээж авах-2-р бүлэг. Хаягдал уснаас дээж авах</li> <li>MNS5667-2:2001. Усны чанар-Дээж авах-3-р бүлэг. Авсан дээжийг зөөвөрлөх, хадгалах арга</li> </ul>
	Цэвэршүүлсэн саарал ус					
Амьтны аймаг	Дөргөн нуурын орчимд	<ul style="list-style-type: none"> <li>Нүүдлийн шувууд</li> <li>Ховор ан амьтан</li> </ul>	Жилд 1 удаа	1 000.0	1 000.0	

<b>Ургамлан нөмрөг</b>	Төслийн талбай орчим	<ul style="list-style-type: none"> <li>Ургамлын зүйл</li> <li>Бодгалийн тоо, бүрхэц</li> <li>Дундаж өндөр</li> <li>Биомасс</li> </ul>	Жилд 1 удаа	1 000.0	1 000.0	<ul style="list-style-type: none"> <li>Тухайн орчны байгалийн унаган төрхөөрөө байгаа экосистемтэй харьцуулах аргаар тодорхойлох</li> </ul>
<b>2024 оны байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн нийт зардал</b>						<b>3 400.0</b>

#### 4.3. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, Хянан батлах, тайлагнах журмын дагуу тухайн жилийн БОМТ-г боловсруулж батлуулах ба БОМТ-ний биелэлтийг тайлагнах үүргийг хүлээнэ.

Төсөл хэрэгжүүлэгч нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, Хянан батлах, тайлагнах журмын 2.2-т заасны дагуу 2024 оны БОМТ төлөвлөгөөг 1 сарын дотор байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө боловсруулан ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад батлуулахаар хүргүүлнэ.

Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ханган биелүүлж түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор дээр дурдсан журмын 3-р хавсралтын дагуу гаргаж, харьяалагдах аймгийн байгаль орчны газарт 3-аас доошгүй хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

**Хүснэгт 17. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө**

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг
1	Орон нутгийн байгаль орчны хэлтэс ба тухайн багийн ИНХ-д танилцуулах	Хэвлэмэл цаасан тайлан, илтгэл хэлбэрээр танилцуулна.	Төслийн үйл ажиллагааны танилцуулга болон Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хийж гүйцэтгэсэн ажил, хийхээр төлөвлөж байгаа ажлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэлтэй байна.	10-р сард	Дотоод зардал
2	Говь-Алтай аймгийн байгаль орчны газар	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан /Баримт бичгийн бүрдэл, хэвлэмэл хэлбэрээр тайланг хүргүүлнэ/		11-р сарын 01	Дотоод зардал
3	БОАЖЯ-ны ХБОБНГ-т	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулах /Баримт бичгийн бүрдэл, хэвлэмэл хэлбэрээр тайланг хүргүүлнэ/		12-р сард	Дотоод зардал
<b>Нийт</b>			-		